



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2024 оны 08 дугаар
сарын 09 өдөр

Дугаар 298/2024

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

| | | |
|---|---|--------------------------|
| Объектын нэр: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэлх авто зам) ажлын төсөв | |
| Объектын байршил: | Улаанбаатар хот | |
| Хүчин чадал: | 3.23 км | |
| Захиалагч: | Нийслэлийн замын хөгжлийн газар | |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Нийслэлийн замын сан | |
| Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр | "Keapo" ХХК | |
| Регистрийн дугаар: | 5086833 | |
| Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: | 2028.05.16 | |
| Зураг төсөл боловсруулах үндэслэл: | | |
| Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Нийслэлийн замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталсан авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, № 240104073, | |
| Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ болон "Keapo" ХХК-ийн хооронд 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан авто замд засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, №ХТСИОНӨААТҮГ/20240203031 Зургийн гэрээний үнэ: 22 523 511 төгрөг, | |
| Зураг төслийн бүрэлдэхүүн: | | |
| Зургийн бүрдэл: | Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Шалгасан экспертний нэр: |
| Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын төсөв | "Keapo" ХХК | Л.Баасанбат |
| Ерөнхий дүгнэлт: | | |
| Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын ажлын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт: | Орон тооны бус экспертний дүгнэлтийн дагуу төсөвт холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж, дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд: <u>Төсөвт өртөгт:</u> Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын төсөвт /2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дүгнэлт/ Дээрх дүгнэлт нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно. | |
| Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт | Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд: -ЗЗБНБД 81-013-2019 "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" -ЗЗБНБД 83-25-2023 "Авто замын барилгын төсвийн жишиг норм", -ЗЗБНБД 83-28-2023 "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" -ЗЗБНБД 83-26-2023 "Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм" | |
| Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт | Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Үүнд: Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын төсөв 4 275 013 003 төгрөг Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянав. | |

“Авто замын тухай” хуулийн 19.4, 19.5-д тус тус заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.”

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэлх авто зам) ажлын төсвийг холбогдох норм дүрмийн шаардлагад нийцүүлэн тооцсон байна

Тус төсвийн баримт бичигт “Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй.
(Хавсралт: 4 хуудас)

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН ТӨСВИЙН МАГАДЛАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Х.ПҮРЭВЖАРГАЛ

С.БААСАНСҮРЭН

Г.АНХЦЭЦЭГ

С.МӨНХТУЯА

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /ТӨСВИЙН ТООЦОО/

| д/д | Утга | Тайлбар |
|-----|---|---|
| 1 | Объектийн байршил, хүчин чадал | УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажил Замын урт- 3.23 км. |
| 2 | Объектийн нэр, шифр | УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажлын төсөв |
| 3 | Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага | УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажлын төсөв-1 дэвтэр Зураг төслийн байгууллага: "Кеаро" ХХК |
| 4 | Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер | Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019, 2 дугаар хавсралтаар баталсан "Зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг", 3 дугаар хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн машин ашиглалтын нэг машин цагийн үнэ", 4 дүгээр хавсралтаар баталсан "Автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн.км-ийн жишиг тариф"-ыг ашиглан төсөв бодох компьютерийн "Road-Estimator" программ ашиглан төсвийн тооцоог хийсэн байна. УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажлын төсвийг "Кеаро" ХХК, төсөвчин О.Лхагвасүрэн хийж, Мэргэшсэн төсөвчин М.Ган-Эрдэнэ хянасан байна. Магадлалд ирүүлсэн төсвийн дүн- 4 358 584 347 төгрөг |
| 5 | Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал | Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг төсвийн тооцоонд хавсаргасан байна. |
| 6 | Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ | Төсвийн тооцоог ЗЗБНБД 83-25-2023, ЗЗБНБД 83-26-2023, ЗЗБНБД 83-28-2023 суурь жишиг нормоор үнэлсэн байна. |
| 7 | Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал | Төсвийн тооцооны иж бүрдэл хангагдсан байна. |
| 8 | Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт | Төсвийн тооцоонд хавсаргах шаардлагатай материалууд: Үүнд: - Ажлын тоо хэмжээг зургийн инженер, зургийн экспертээр баталгаажуулж магадлалын ерөнхий дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх. (боломжгүй тохиолдолд захиалагчаар баталгаажуулах) |

| | | |
|--|---|---|
| | | <ul style="list-style-type: none"> - Төсөвт голлох материалын тээврийн зайг программын тайлбар бичигт хүснэгтээр, схем зургаар (шороон ордоос, үйлдвэрээс тээвэрлэх) бодитой тооцон гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулан экспертийн дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх - Төсвийн тайлбар бичигт төсөвт голлох материалын үнийн судалгаа, хаанаас худалдан авахаар тооцсон талаарх мэдээллийг программын тайлбар бичигт оруулах <p>Төсвийн тооцоонд дараах өөрчлөлтийг оруулж, дахин хянуулах шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Том ширхэглэлтэй халуун асфальтбетон хольц, Жижиг ширхэглэлтэй халуун асфальтбетон хольцны үнийг дахин хянаж шалгах - Худаг өндөрлөх ажлын материалын орц нормыг ажлын зургийн дагуу тооцох /ажлын зургийг ирүүлэх/ - Хаягдал материалын тээврийн зайг бодитой тооцох /бусад бүх материалын тээврийн зайг судалгааны үндсэн дээр тооцох/ - Хаягдал материалын үнийг 1 тн 5000 төгрөгөөр тооцох /хог хаягдлын хураамж/ - Ажлын тоо хэмжээг зургийн эксперт, захиалагчаар баталгаажуулах |
| | <i>Дүгнэлтийн товч утга</i> | |
| 1 | Төсвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу оновчтой зохиогдсон эсэх | УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажлын төсвийн тооцоог хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн суурь норм, төсөв бодох нормын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Магадлалын дүгнэлтээр тодорхойлсон алдаа дутагдлыг засаж экспертийн дүгнэлтийн хариуг ирүүлсэн тул төсвийг 4 275 013 003 төгрөгөөр хянав. |
| <p>Дүгнэлт бичсэн:</p> <p style="text-align: center;">Эксперт №12-03  Л.Баасанбат</p> <p style="text-align: center;">2024 оны 7 дугаар сарын 08-ны өдөр</p> | | |

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2
ЭКСПЕРТИЙН ДҮГНЭЛТИЙН ХАРИУ

2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|-----|-------------------------------|---|
| 1 | Объектын нэр | УБ хот, Зайсангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлтийн (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр хүртэл) ажил |
| 2 | Объектын байршил, хүчин чадал | Замын урт- 3.23 км. |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Кеаро" ХХК |

| Д/д | Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил | Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тайлбар, танилцуулга |
|-----|--|--|
| 1 | <p>Төсвийн тооцоонд хавсаргах шаардлагатай материалууд: Үүнд-</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын тоо хэмжээг зургийн инженер, зургийн экспертээр баталгаажуулж магадлалын ерөнхий дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх. (боломжгүй тохиолдолд захиалагчаар баталгаажуулах) - Төсөвт голлох материалын тээврийн зайг программын тайлбар бичигт хүснэгтээр, схем зургаар (шороон ордоос, үйлдвэрээс тээвэрлэх) бодитой тооцон гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулан экспертийн дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх - Төсвийн тайлбар бичигт төсөвт голлох материалын үнийн судалгаа, хаанаас худалдан авахаар тооцсон талаарх мэдээллийг программын тайлбар бичигт оруулах | <ul style="list-style-type: none"> - Ажлын тоо хэмжээг зургийн инженерээр баталгаажуулан хавсаргав. - Голлох материалын тээврийн зайг программын тайлбар бичигт хүснэгт схем зургаар гарган тооцон баталгаажуулан хавсаргав. - Тайлбар бичигт голлох материалын үнийн судалгааны мэдээллийн хамт программын тайлбар бичигт оруулав. |
| 2 | <p>Төсвийн тооцоонд хавсаргах шаардлагатай материалууд: Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Том ширхэглэлтэй халуун асфальтбетон хольц, Жижиг ширхэглэлтэй халуун асфальтбетон хольцны үнийг дахин хянаж шалгах | <ul style="list-style-type: none"> - Асфальтбетон хольцын үнийг дахин хянаж засварлан отуулав. |

| | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> - Худаг өндөрлөх ажлын материалын орц нормыг ажлын зургийн дагуу тооцох /ажлын зургийг ирүүлэх/ - Хаягдал материалын тээврийн зайг бодитой тооцох /бусад бүх материалын тээврийн зайг судалгааны үндсэн дээр тооцох/ - Хаягдал материалын үнийг 1 тн 5000 төгрөгөөр тооцох /хог хаягдлын хураамж/ - Ажлын тоо хэмжээг зургийн эксперт, захиалагчаар баталгаажуулах | <ul style="list-style-type: none"> - Худаг өндөрлөх ажлын материалын орц нормыг ажлын зургийн дагуу тооцон, ажлын зургийг хавсарган оруулав. - Хаягдал материалын тээврийн зайг Улаанчулуутын хогийн цэгт хаяхаар тээврийн зайг тооцож оруулав. - Хаягдал материалын үнийг 1 тн 5000 төгрөгөөр тооцон оруулав. - Ажлын тоо хэмжээг баталгаажуулан хавсаргав. |
| <p>Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт /Л.Баасанбат/ 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр</p> <p>Биелэлтийн тайлбар бичсэн Мэргэшсэн төсөвчин /М.Ган-Эрдэнэ/ 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр</p> | |



Экспертийн дүгнэлтийг компьютерээрээ 2 хувь бичиж, гарын үсэг тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.